

**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг биелүүлж, бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, тайлангийн хугацаанд 10 удаа хуралдаж, 18 асуудал хэлэлцэж, 54 заалт бүхий 19 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журмын дагуу зарлан хуралдуулж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85,56 хувийн ирцтэйгээр төвлөсөн хугацаанд болсон хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналын эрхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хууль, төрийн зохицуулах байгууллагаас тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүд, дарга, нарийн бичгийн дарга нар 100 хувь компанийн засаглалын сургалтад хамрагдан ажиллаж ирэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороодыг ажиллуулж байна.

Компанийн 2014 оны жилийн санхүүгийн тайлан тэнцлийг шалгаж баталгаажуулах, аудит хийх аудитын компаниар сонгон шалгарсан Мэдээлэл-Аудит (ХХ) компани холбогдох хууль тогтоомжийн дагуу аудитын тайлан дүгнэлтийг гаргасан байна.

Компанийн тухай хууль болон компанийн ногдол ашгийн бодлогын журмын дагуу 2014 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг даруй 17 төгрөгөөр нэмэгдүүлэн 82,0 төгрөгөөр тогтоож, 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 623 хувьцаа эзэмшигчдэд 97,578,606 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргаж, Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан хувьцаа эзэмшигчдэд олгох ажлыг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид тайлагнасан байна.

Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийн дагуу Тахько (ХК) компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулах талаар 2014 оны 08 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулж, эчнээ санал хураалтад саналын эрхтэй 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид оролцохоос саналын эрхтэй 642,631 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид саналаа ирүүлж, нийт саналын эрхийн 54 хувь санал хураалтад оролцож, эчнээ санал хураалтаар санал авсан асуудлаар саналын эрхийн олонхоор шийдвэрлэсэн байна.

Мөн компанийн хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгээс ирүүлсэн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас 272,775 ширхэг энгийн хувьцааг хасаж, Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, хүчин төгөлдөр саналын эрхтэй 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид оролцохоос 1,052,292 саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчид оролцож, 88,4 хувийн хурлын ирцтэйгээр хуралдаж, 641,268 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид буюу

нийт саналын эрхийн 60,94 хувийг эзэмшигчид Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаас татгалзаж, ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлыг саналын эрхийн олонхоор шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2014 онд холбогдох хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, заавар, засаглалын кодекс, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажилласнаар Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 237 хувьцаат компаниас 4-р байранд шалгарч зохих шалгуур, үзүүлэлтийг хангалттай биелүүлсэн компанийн нэг болсон байна.

Тахько (ХК) компанийн захиргаа, гүйцэтгэх удирдлага нь 2014 онд Төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлуулж, үүний дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захиралтай контрактын гэрээ байгуулж ажиллав.

Компанийн захиргаа тайлангийн хугацаанд удирдлага, захиргааны ба техник үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй, ажлын байрны 23 орон тоо бүхий бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэсэн бөгөөд компанийн дотоод дэг журам, ажлын зарчим, эрх үүрэг, шийтгэл, хариуцлага, ажилд авах, чөлөөлөх, ажил, амралтын цагийн горим, чөлөө олгох, цалин, хөлс, нэмэгдэл, буцалтгүй тусламж зэрэг асуудлыг тодорхой багтаасан Хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллав.

Ахмадын баярыг тохиолдуудан Оёдлын үйлдвэрийн нэгдэл, Тахько компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 300 гаруй ахмад настныг, Хөнгөн аж үйлдвэр үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан оёдлын үйлдвэр, тус компанид ажиллаж байсан 30 гаруй удирдах ажилтныг, цагаан сарын баярыг тохиолдуулан тус компанид ажиллаж байсан 70 ба түүнээс дээш насны 15 ахмадыг тус тус хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Түүнчлэн, оёдлын үйлдвэрээс төрсөн хөдөлмөрийн баатар 2, гавъяат ажилтан 1 хүнд жилд 2 удаа байнгын тэтгэмж олгодог боллоо.

2004 онд байгуулсан компанийн үл хөдлөх хөрөнгийг 10 жилийн хугацаагаар түрээсэлсэн түрээс, үйлчилгээний гэрээний хугацаа 2014 оны 7 дугаар сард дуусгавар болохтой холбогдуулан үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээг дахин хийлгүүлж, тэдгээр (МА-I, МА-II, U-I барилга)-ийг үргэлжлүүлэн түрээслэх их хэмжээний хэлцэл хийхэд шаардлагатай зах зээл, үнийн судалгааг ажлын хэсэг, мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, уг судалгаанаас гарсан дүгнэлтийг үндэслэн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргуулж, их хэмжээний хэлцэл хийхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулж, гэрээ байгуулах бэлтгэлийг урьдчилан хийсэн. Энэхүү зах зээлийн судалгаа, дүгнэлтийг үндэслэн шинээр байгуулах гэрээний төслийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан боловсруулж, түрээсийн гэрээний төлбөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоож, талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг өмнөх гэрээнээс илүү ойлгомжтой тодорхой болгож, зах зээлийн үнэ ханш, инфляцийн өөрчлөлттэй холбогдуулан түрээсийн төлбөрийг нэмэх, өөрчлөх зохицуулалтыг гэрээнд шинээр тусгаж түрээс, үйлчилгээ, талбайн ашиглалтын гэрээнүүдийг амжилттай байгуулсан.

Үндсэн түрээслэгч Ньютел (ХХ) компанитай байгуулсан удаан хугацааны түрээсийн гэрээнүүд дуусгавар болж МА-I барилгын 1, 2 давхарын 1,164 м² талбайг Скайтел (ХХ) компанид, МА-II барилга (ТЕДИ төв)-ын 1 давхарын 1,079.6 м² талбай, U-I барилгын 1 давхарын 421.13 м² талбай, МА-III барилгын 95.25 м² талбайг Мобиком корпорацид, МА-II барилга (ТЕДИ төв)-ын 2, 3, 4 давхарын 2,997 м² талбайг Ньюком проперти (ХХ) компанид нийт 5,757 м² талбайг 3 жилийн хугацаагаар тус тус түрээслүүлэх гэрээг амжилттай хийж, 12

дугаар сараас эхлүүлснээр түрээсийн сарын орлогыг өмнөх үеийнхээс 2.37 дахин нэмэгдүүлж чадлаа.

Тайлант хугацаанд урт хугацааны гэрээнүүд дуусгавар болсонтой холбогдуулж шинээр түрээслэгч нарыг оруулахтай холбоотойгоор их хэмжээний хөрөнгө оруулалт, их засварын ажлууд хийгдлээ. Тухайлбал, МА-I барилгын дулаан болон сантехник, цэвэр бохир усны системүүдийн шинэчлэл, түүнтэй холбоотой барилгын засвар тохижилтын ажил, МА-I, МА-II барилгыг холбосон хүзүүвч болон МА-III барилгын дээврийг сэргээх ажил, МА-III барилгын сантехник, дотоод засвар тохижилт, гал, холбоо дохиоллын засварын ажил, U-II, U-III барилгыг холбосон аркны замын засварын ажил зэрэг барилга байгууламжийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба нийтдээ их засварт 434,409,381 төгрөг зарцуулсан байна.

МА-III барилгын түрээсийн гэрээ цуцлагдсантай холбоотой уг барилгыг цаашид бизнесийн зориулалтаар ашиглаж, төрөл бүрийн хурал зөвлөлгөөн, сургалт семинар, хүлээн авалт, соёл урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах боломжтой Анкор төв болгон өөрчилж үйл ажиллагааг нь эхлүүлэн ажиллаж байна. МА-III барилгын архитекторын зураг төсөл, дулаан, сантехник, бохир цэвэр усны систем, түүнтэй холбоотой барилгын засвар, дотоод тохижилтын ажил болон тус төвийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авч жилийн эцсийн байдлаар 310,072,130 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна. Ингэснээр тус компанийн үндсэн хөрөнгө 772,531,190 төгрөг байсан бол 1,248,575,252 төгрөг болж 62 хувиар, нийт компанийн хөрөнгийн хэмжээ 2,298,026,851 төгрөг болж өмнөх оныхоос 374,058,000 төгрөг буюу 18 хувиар тус тус өссөн байна.

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох “Хэтийн хөгжил боловсрол, соёл, үйлчилгээний төв” төслийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж, үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн хөгжлийн архитекторын иж бүрэн зураг төслийг гадны хөрөнгө оруулалттай мэргэжлийн компаниар хийлгүүлэхээф тохиролцоод төслийн эхний шатны ажлын зургуудыг боловсруулаад байгаа болно.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 20,137,099 төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн болон газрын албан татвар, 34,238,761.36 төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 90,082,832.29 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалд 58,394,407 төгрөгийн шимтгэл төлж, төсөвт төлөх төлбөрийн 89 хувийг тайлангийн жилд барагдуулжээ.

Хэрэглэсэн цахилгаан, дулаан, ус, газрын төлбөр зэрэг тогтмол зардлын төлбөрийг тогтоосон хугацаанд нь барагдуулж, алданги торгууль хүлээгээгүй, харилцагч байгууллагаас авах төлбөрүүдийг тухай бүрт нь нэхэмжлэн авч орлогыг бүрдүүлж ажиллалаа. Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласнаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй. Олон жил болсон, хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн 113,089,101.42 төгрөгийн найдваргүй авлагыг данс бүртгэлээс хасч авлага 24 хувиар, 17,936,835.69 төгрөгийн өглөгийг данснаас хасч дансны өглөг 94 хувиар тус тус бууржээ.

Компани нь 2014 онд 1,977,408.0 мянган төгрөгийн орлоготой, 1,526,534.6 мянган төгрөгийн зарлагатай, 450,873.4 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай, 394,115.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн нийт орлого 612,888.0 мянган төгрөгөөр, нийт зардал 476,126.6 мянган төгрөгөөр нэмэгдэж,

татварын өмнөх ашиг 136,765.4 мянган төгрөг, татварын дараах ашиг 112,568.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдлээ.

Компанийн нийт орлогыг бүтцээр нь авч үзвэл түрээсийн орлого 1,293,735.2 мянган төгрөг, үйлчилгээний орлого 225,036.3 мянган төгрөг, цахилгаан, дулаан, ус, телефон яриа борлуулсны орлого 309,515.9 мянган төгрөг, цахилгаан, дулаан, усны үйлчилгээ тоолуур, тарифын зөрүүний орлого 52,094.7 мянган төгрөг (нийт үндсэн үйл ажиллагааны орлого 1,880,382.1 мянган төгрөг), үндсэн хөрөнгө борлуулсны орлого 31,818.2 мянган төгрөг, хүүгийн орлого 18,543.8 мянган төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний олз 46,663.9 мянган төгрөг байлаа.

2013 онтой харьцуулбал 2014 онд түрээсийн орлого 623,153.25 мянган төгрөг буюу 93 хувиар, цахилгаан, дулаан, ус, телефон яриа борлуулсны орлого 23,653.5 мянган төгрөг буюу 8 хувиар, цахилгаан, дулаан, усны үйлчилгээ тоолуур, тарифын зөрүүний орлого 16,788.4 мянган төгрөг буюу 48 хувиар тус тус өссөн бол үйлчилгээний орлого нь 74,059.3 мянган төгрөг буюу 25 хувиар буурсан байна. Үйлчилгээний орлого буурсан шалтгаан нь шинээр байгуулсан түрээсийн гэрээнүүдэд (3-4 улирлаас мөрдөж эхэлсэн) үйлчилгээний төлбөрийг түрээсийн төлбөрт оруулж тооцдог болсонтой холбоотой байв.

Нийт жилийн түрээсийн орлогыг түрээслэгч байгууллагаар нь авч үзвэл Ньюком Проперти ХХК – 41 хувь, Ньютел ХХК – 38 хувь, Мобиком Корпораци ХХК – 15 хувь, Скайтел ХХК -3 хувь, Цэгц ХХК, Ганжжав ХХК, Монгол Асейн ХХК тус бүр 1 хувь орчим бүрдүүлжээ.

Өнгөрсөн онд компанийн нийт орлого 1,364,520.0 мянган төгрөг байсан бол 2014 онд 1,977,408.0 мянган төгрөг болж, өнгөрсөн оноос 45 хувиар өсч, төлөвлөгөө 104 хувийн биелэлттэй байлаа

Компанийн нийт зардлыг бүтцээр нь авч үзвэл борлуулалт маркетингийн зардал 309,515.9 мянган төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 1,049,207.1 мянган төгрөг, борлуулсан барааны өртөг 4,897.9 мянган төгрөг, бусад зардал 120,634.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 31,497.6 мянган төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний гарз 10,781.9 мянган төгрөг болсон байна.

Борлуулалт маркетингийн зардал (түрээслэгч байгууллагуудад борлуулсан цахилгаан, дулаан, ус, телефон ярианы төлбөр) болох 309,515.9 мянган төгрөгийг дотор нь задалвал цахилгааны зардал 255,972.5 мянган төгрөг, дулааны зардал 28,455.8 мянган төгрөг, цэвэр бохир усны зардал 23,383.9 мянган төгрөг, телефон ярианы зардал 1,703.7 мянган төгрөгөөс бүрдэнэ. 2014 онд өмнөх жилтэй харьцуулахад борлуулалт маркетингийн зардал 23,653.5 мянган төгрөгөөр буюу 8 хувиар нэмэгдсэн ба энэ нь цахилгаан, дулаан, усны үнэ нэмэгдсэнтэй холбоотой юм.

Ерөнхий ба удирдлагын зардлыг бүтцээр нь задалвал цалингийн зардал 537,955.4 мянган төгрөг, байгууллагаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 58,394.4 мянган төгрөг, газар болон үл хөдлөх хөрөнгийн албан татвар 20,137.1 мянган төгрөг, албан томилолтын зардал 24,994.9 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 3,967.6 мянган төгрөг, шуудан холбооны зардал 12,430.8 мянган төгрөг, мэргэжлийн үйлчилгээний зардал 201,599.4 мянган төгрөг, сургалтын зардал 6,510 мянган төгрөг, даатгалын зардал 2,589.7 мянган төгрөг, ашиглалтын зардал 32,988.7 мянган төгрөг, засварын зардал 12,770.5 мянган төгрөг, элэгдэл хорогдлын зардал 74,484.7 мянган төгрөг, харуул хамгаалалтын зардал 11,000.0 мянган төгрөг, цэвэрлэгээ үйлчилгээний зардал 1,046.1 мянган төгрөг, тээврийн зардал 9,101.2 мянган төгрөг, шатахууны зардал 13,734.9 мянган төгрөг, хүлээн авалтын зардал 25,444.5 мянган төгрөг, зар сурталчилгааны зардал 57.0 мянган төгрөг байна. Ерөнхий ба удирдлагын зардал нэмэгдсэн нь цалин, шагнал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, элэгдэл хорогдлын зардал, сургалтын зардал, хангамжийн материал акталсны зардал, бизнес, маркетинг, төслийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин

даатгалын зардал, ашиглалтын зардал, шуудан холбооны зардлуудыг хэмнэж ажилласан ба нийт зардлыг авч үзвэл төлөвлөснөөс 10 хувиар хэмнэж ажилласан байна.

Бусад зардал болох 120,634.2 мянган төгрөг нь хандив буцалтгүй тусламжийн зардал 6,961.1 мянган төгрөг, хүү торгуулийн зардал 584.0 мянган төгрөг, найдваргүй авлагын зардал 113,089.1 мянган төгрөгөөс бүрдэж байна.

Санхүүгийн тайлангийн хураангуй ба эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дор дурдсан байдлаар танилцуулж байна. Үүнд:

2014 оны жилийн тайлан тэнцлийн хураангуй үзүүлэлт (төгрөгөөр)

Балансын Зүйл	Үлдэгдэл		Балансын зүйл	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн		Эхний	Эцсийн
А. Хөрөнгө	х	х	Б. Өр төлбөр эзэмшигчийн өмч	Х	х
I.Эргэлтийн хөрөнгийн дүн	1,088,836,076.1 6	959,447,543.77	I. Өр төлбөрийн дүн	22,539,328.53	34,893,699.06
Мөнгөн хөрөнгө	592,016,719.46	539,491,825.54	Богино хугацаатай өр төлбөр	22,539,328.53	34,893,699.06
Богино хугацаатай хөрөнгө оруулалт			Урт хугацаатай өр төлбөр		
Авлага	453,531,869.07	364,370,220.91	Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр		
Бараа материал	42,100,037.63	50,842,507.32	II. Өмчийн дүн		
Үндсэн ба туслах материал			Төрийн		
Урьдчилж төлсөн тооцоо	1,187,450.00	4,742,990.00	Хувийн		
Бусад			III. Хувьцаа дүн	199,917,144.0	199,917,144.0
II. Биет хөрөнгийн дүн	772,531,190.13	1,248,575,252.1 7	Энгийн хувьцааны тоо, ширхэг	1,189,983	1,189,983
Барилга байгууламж	1,197,729,870.9 8	1,593,026,286.4 3	Нэрлэсэн үнэ	168	168
Газар			Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг		
Машин тоног төхөөрөмж	18,478,102.73	77,381,651.82	Нэрлэсэн үнэ		
Тавилга, эд хогшил	145,445,161.30	195,830,551.48	Халаасны хувьцааны дүн		
Бусад.	235,641,930.00	261,063,687.00			

тээврийн хэрэгсэл					
Хуримтлагдсан элэгдэл	824,763,874.88	878,726,924.56	IV. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	387,604,403.3	387,604,403.3
III. Биет бус хөрөнгийн дүн	1,600,967.89	2,003,136.14	V. Хуримтлагдсан ашиг	1,340,908,278.35	1,675,611,605.62
			Үүнээс: Тайлант үеийн ашиг	281,547,268.83	394,115,386.58
IV. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	88,000,920.00	88,000,920.00	VI. Эзэмшигчийн өмчийн дүн	1,928,429,825.65	2,263,133,152.92
Нийт хөрөнгийн дүн	1,950,969,154.18	2,298,026,851.98	VII. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,950,969,154.18	2,298,026,851.98

Компанийн нийт ашиг (мянган төгрөгөөр)

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2011	2012	2013	2014
1. Цэвэр борлуулалт	997,621.5	930,659.2	1,364,520.0	1,977,408.0
2. Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг				4,897.9
3. Үйл ажиллагааны зардал	714,394.3	651,855.7	1,050,412.1	1,526,534.6
4. Татварын өмнөх ашиг	283,227.2	278,803.5	314,107.9	450,873.4
5. Орлогын татварын зардал	30,444.9	30,870.9	32,560.7	56,758.0
6. Татварын дараах ашиг (цэвэр ашиг)	252,782.3	247,932.6	281,547.2	394,115.4

Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашиг (төгрөгөөр)

Он	1992	1993	1994-1995	1998-1999	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Төг	8.55	2.41	5.48	28.60	16.25	18.12	36.0	45.00	56.00	56.00	56.0	56.0	65.00	82.00

Үзүүлэлт	2011	2012	2013	2014
1. Хувьцааны арилжааны дундаж ханш (төгрөгөөр)	4,291.36	5,772.04	7,324.10	10,055.60
2. Хувьцааны дансны үнэ (төгрөгөөр)	1,287.60	1,439.95	1,620.55	1,901.82
3. Хувь нийлүүлэгчдийн тоо	636	626	623	624
4. Хувьцааны төвлөрлийн хувь	84.29	79.25	83.93	83.93

Тахько (ХК) компанийн нийтэд чөлөөтэй арилжаалагдсан энгийн хувьцааны арилжааны 2014 оны жилийн дундаж ханш 10,055.60 төгрөг, дансны дундаж үнэ 1,901.82

төгрөг болж, компанийн зах зээлийн үнэлгээ 2014 оны эцсээр 13,089,813.0 мянган төгрөгт хүрсэн байна.

Компанийн санхүүгийн харьцааны шинжилгээ

Харьцаанууд	Тооцоолол	2013	2014	Өөрчлөлт
Цэвэр ашгийн харьцаа	Татварын дараах ашиг/Нийт орлого	0.28	0.21	-0.07
Хөрөнгийн өгөөж	Цэвэр ашиг/Нийт хөрөнгө	0.14	0.17	0.03
Өмчийн өгөөж	Цэвэр ашиг/Хувьцаа эзэмшигчдийн өмч	1.41	1.97	0.56
Ногдол ашгийн өгөөж	Нэгж хувьцааны ногдол ашиг/Хувьцааны үнэ	39%	43%	4%

2014 оны жилийн эцсийн тайланг санхүүгийн чадвар, ашигт ажиллагааны харьцаа, ногдол ашгийн харьцаагаар авч үзвэл хөрөнгийн өгөөж 0.03, өмчийн өгөөж 0.56, ногдол ашгийн өгөөж 4 хувиар нэмэгдсэн эерэг үзүүлэлтэй байна.

КОМПАНИЙН 2014 ОНЫ АЖЛЫН ТАЛААРХ ҮНДСЭН ДҮГНЭЛТ

2014 онд Монгол Улсынэдийн засгийн хүндрэлтэй орчин, бараа, ажил үйлчилгээний үнийн өсөлт, инфляцийн түвшин зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлдөг нөхцөл нь сайнгүй байсан боловч компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага идэвх зүтгэлтэй ажилласны үр дүнд компанийн санхүү, эдийн засгийн гол гол үзүүлэлтүүд дээшилсэн байна.

Тахько (ХК) болон Ньютел (ХХ) компанийн хооронд байгуулсан 10 жилийн хугацаатай түрээсийн гэрээний хугацаа нь 2014 онд дуусгавар болсонтой холбогдуулан Мобиком, Ньюком проперти, Скайтел (ХХ) компанитай түрээсийн гэрээг амжилттай шинэчлэн хийж, компанийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэн тогтвортой үйл ажиллагааг ханган ажилласан гэж дүгнэж байна.

Тайлангийн хугацаанд компанийн нийт орлого 1,977,708,0 мянган төгрөг болж өмнөх оныхоос даруй 612,888,0 мянган төгрөгөөр буюу 45 хувиар өсөж, 394,115.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Мөн 2014 оны санхүүгийн тайлан тэнцлээр компанийн нийт хөрөнгө 2,298,026,851 төгрөг, үүнээс 915,621,700 төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй болсон бөгөөд тайлангийн хугацаанд 476,044,062 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Компанийн тухай хууль, компанийн ногдол ашгийн бодлогын журмыг үндэслэн өмнөх онд нэгж хувьцаанд хувиарласан ногдол ашгийн хэмжээ 65,0 төгрөг байсныг нэмэгдүүлж 2014 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг 82 төгрөгөөр тогтоож, нийт энгийн 1,189,983 ширхэг хувьцаанд 97,578,606 төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцээд компанийн гүйцэтгэх удирдлага, нийт ажиллагсад 2014 оны зорилтот төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж, компани, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Компанийн орлого өссөн нь компанийн ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх нөхцөл, санхүүгийн боломжийг бий болгосноор ажилтнуудын үндсэн цалинг 2015 оны 01 дүгээр сарын 1-нээс 2 дахин нэмэгдүүлсэн бөгөөд цалин урамшууллын журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөж эхлээд байна.

- Цаашид компанийн үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулахад дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна:
- Цалин, урамшууллын системийг сайжруулах тал дээр анхааран ажиллах;
- “Далайван Аудит” (ХХ) компаниар үнэлүүлсэн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг холбогдох хууль тогтоомж, стандарт, журмын дагуу бүртгэл тайландаа тусгах;
- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг олон улсын стандартад нийцүүлэн холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллах;
- Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн цар хүрээ, ашиг орлогыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах

Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж байна.

Энэхүү дүгнэлтийг Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэж 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн эчнээ санал хураалтаар батлав.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Л.БУЯНБАТ